# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 12 өдөр          Дугаар 137          Улаанбаатар хот

## Албан тушаалын тодорхойлолт батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 23.6-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөрөнгө оруулалт, худалдааны газрын даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралт ёсоор батлсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД          Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА          Д.АМАРБАЯСГАЛАН

Засгийн газрын 2023 оны 04 дүгээр
сарын 12 -ны өдрийн 137 дугаар
тогтоолын хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I.ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

| | |
|---|---|
| Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо: | |
| Дагаж мөрдөх огноо: | |
| Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо: | |
| Байгууллагын нэр: Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Хөрөнгө оруулалт, худалдааны газар | Нэгжийн нэр: |
| Албан тушаалын нэр: Газрын дарга | Албан тушаалын ангилал, зэрэглэл: Тэргүүн түшмэл, ТЗ-1 |
| Ажлын цаг: Ажлын өдөр 8 цаг | Ажлын байрны албан ёсны байршил: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Нэгдсэн Үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр |
| Хөдөлмөрийн нөхцөл: Хэвийн | Онцгой нөхцөл: Хамаарахгүй |

## II.АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн нэгдсэн бодлогыг хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалт, худалдааны орчныг сурталчлах, хөрөнгө оруулалтыг татах, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд чиглэсэн цогц үйл

| |
|---|
| ажиллагаа зохион байгуулах, хөрөнгө оруулалт, худалдааны үр ашгийг макро эдийн засгийн зорилттой уялдуулах чиг үүргийн хүрээнд газрын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэлийн үр дүнг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын өмнө хариуцна. |
| <u>Албан тушаалын зорилт</u>:<br>1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, Засгийн газраас гаргасан шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулалт татах, хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг үзүүлэх;<br>2.Гадаадын хөрөнгө оруулагчдад зориулсан “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйл ажиллагааг эрхлэн зохион байгуулж, төрийн байгууллын үйлчилгээг шуурхай үзүүлэх;<br>3.Импортыг орлох салбарыг хамгаалж, экспортын чадавхыг дэмжих, өрсөлдөх чадварыг сайжруулахад чиглэсэн бодлого, зохицуулалтын хэрэгжилтийг хангах, худалдааны алдагдлыг багасгах, тарифын болон тарифын бус арга хэрэгслийг зохистой хэрэглэж, Монгол Улсын нэгдэн орсон, байгуулсан худалдааны чиглэлээрх олон болон хоёр талт гэрээ, хэлэлцээрийн үр ашгийг бүрэн ашиглах;<br>4.Худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөхөд чиглэсэн бодлого, зохицуулалтын хэрэгжилтийг хангах, хил дамнасан цахим худалдааг хөгжүүлэх, олон улсын түвшний гадаад худалдааны цахим нэг цонхны системийг нэвтрүүлэх, төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх;<br>5.Монгол Улсын хөрөнгө оруулалт, худалдааны орчны талаарх мэдээлэл, хөрөнгө оруулалт эрэлхийлж буй төслүүдийг гадаадын хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд танилцуулж, сурталчлах зорилгоор бизнес/хөрөнгө оруулалтын форумыг санаачлан зохион байгуулах, олон улсын форум, уулзалт, үзэсгэлэн зэрэг арга хэмжээнд оролцох бэлтгэл ажлыг хангах;<br>6.Монгол банк, санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн бирж, хөдөлмөр эрхлэлт, татвар, гааль, бүртгэл, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудтай хамтран хөрөнгө оруулалт, худалдааны нэгдсэн статистик мэдээллийг гаргах, дүн шинжилгээ хийх;<br>7.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт тавих дотоод хяналт шалгалт, дотоод хяналт шинжилгээний тогтолцоог бий болгох, удирдлагын шийдвэр, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, аппаратын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх;<br>8.Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах, удирдлагын шийдвэр гаргалтад эрх зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах, төрийн захиргааны болон хүний нөөцийн манлайллыг хангах, аппаратыг хэвийн ажиллах нөхцөлөөр хангах. |

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Гүйцэтгэх-Г Хянах-Х Шийдвэрлэх -Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Хөрөнгө оруулалтын тухай хууль тогтоомж, холбогдох төрийн байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хөрөнгө оруулалтын бодлогод дэмжлэг үзүүлэх; | Хуульд нийцсэн үндэслэл бүхий санал боловсруулсан байна. | Х, Ш |
| | 2.Хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар гадаад, дотоодын байгууллагуудыг мэдээллээр хангах; | Гадаад, дотоодын байгууллагуудыг мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Х, Ш |
| | 3.Хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны төлөвлөлт хийх, хөрөнгө оруулалтыг тогтвортой үргэлжлүүлэхэд дэмжлэг үзүүлэх; | Хуулийн хэрэгжилтийг хангаж мэргэшил арга зүйн дэмжлэг үзүүлж, удирдан зохион байгуулсан байна. | Х, Ш |
| | 4.Хөрөнгө оруулалт эрэлхийлсэн дэд бүтэц, уул уурхай, эрчим хүч, хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон бусад салбарын тэргүүлэх төслүүдэд хөрөнгө оруулалт татах, төслийн мэдээллийн сан үүсгэх, цахим хуудсаар сурталчлах; | Хөрөнгө оруулалтыг татах, мэдээллийн сан үүсгэсэн байх, цахим сурталчилгаа хийгдсэн байна. | Х, Ш |
| | 5.Хөрөнгө оруулалтын талаарх эрх зүйн орчин, дотоод зах зээлийн таатай нөхцөлийг хөрөнгө оруулагчид сурталчлах, таниулах; | Хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, хөрөнгө оруулалтыг татах, сурталчлах, таниулсан байна. | Х, Ш |
| | 6.Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр дэмжлэг үзүүлэх. | Хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, дэмжлэг үзүүлсэн байна. | Х, Ш |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 1.Гадаадын хөрөнгө оруулалтын “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйл | Үйл ажиллагааг хэрэгжүүлж, эргэн тайлагнасан байна. | Х, Ш |

| | | | |
|---|---|---|---|
| | ажиллагааг тогтвортой, тасралгүй хэвийн явуулах, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг боловсронгуй болгох арга хэмжээг хэрэгжүүлэх; | | |
| | 2.Гадаадын хөрөнгө оруулагчдын хүсэлт, саналыг судалж, шийдвэрлэх, хөрөнгө оруулагчийн тодорхойлолт олгох ажлыг зохион байгуулах; | Хууль тогтоомжид нийцүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй зохион байгуулсан байна. | Г, Х |
| | 3.Гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлэх төрийн үйлчилгээг цахимжуулах арга хэмжээг зохион байгуулж, "Цахим нэг цонхны үйлчилгээ"-г нэвтрүүлэх; | Хууль тогтоомжид нийцүүлж, төрийн үйлчилгээг шуурхай, хүртээмжтэй зохион байгуулсан байна. | Г, Х |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Байгууллагын чиг үүрэг, стратеги төлөвлөгөөтэй уялдуулан нэгжийн үйл ажиллагаанд эрсдэл тооцож, төлөвлөгөөний төслийг боловсруулан, батлуулах, хэрэгжилтэд хяналт тавих; | Гүйцэтгэлийн төлөвлөгөө нь байгууллагын стратеги, гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдсан байна. | Х, Ш, Г |
| | 2.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, ажил үүргийн хуваарийг гүйцэтгэлийн төлөвлөгөөтэй уялдуулан жил бүр, шаардлагатай тохиолдолд тухай бүр гарган, хэрэгжилтэд хяналт тавих, үйл ажиллагааг оновчтой удирдан зохион байгуулах; | Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд ажил үүрэг давхцахгүй, орхигдохгүй байхаар төлөвлөгдсөн байна. | Х, Ш, Г |
| | 3.Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийн нэгж, дэргэдэх байгууллага, харьяа гаалийн газар, хороодыг хорио цээрийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдох асуудлаар удирдамж чиглэлээр хангаж, үүрэг даалгавар, зөвлөгөө өгөх, хяналт тавих, сургалт зохион байгуулах; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Х, Ш |

| | | | |
|---|---|---|---|
| | 4.Төрийн албаны тухай хууль, бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн зарчим, манлайллыг удирдлага болгон ажиллах; | Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэсэн байна. | Г, Х |
| | 5.Архив, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн баримт бичгийн төсөл боловсруулах, архивын нэгж бүрдүүлэх ажилд хяналт тавих; | Албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцсэн байна. | Х |
| | 6.Нэгжийн чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой программ хангамжийн хөгжүүлэлт, мэдээллийн сангийн баяжуулалт хийх ажлыг удирдан зохион байгуулах; | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо, үр дүн | Х, Ш |
| | 7.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь биелүүлэх, олон нийтийг хамруулсан арга хэмжээ зохион байгуулах, оролцох, хамт олныг хамруулах. | Хамт олныг хамруулан зохион байгуулсан арга хэмжээ, хурал, цуглааны тоо, үр дүн | Ш, Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Худалдаанд тулгарч буй саад хүндрэлийг багасгаж, хөнгөвчлөхөд чиглэсэн бодлого, зохицуулалтын хэрэгжилтийг хангах; | Гадаад, дотоод хамтын ажиллагаа өргөжсөн байна. | Г, Х |
| | 2.Хил дамнасан цахим худалдааг хөгжүүлэх, олон улсын түвшний гадаад худалдааны цахим нэг цонхны системийг нэвтрүүлэх; | Төрийн үйлчилгээ шуурхай, цахимжсан, хүртээмжтэй зохион байгуулсан байна. | Г |
| | 3.Худалдаатай холбоотой зөвлөгөө өгөх, төрийн үйлчилгээг шуурхай үзүүлэх. | Төлөвлөгөөг хуулийн хугацаанд баталж хэрэгжилтийг ханган ажилласан байна. | Х, Ш |
| 5 дугаар зорилтын хүрээнд | 1.Монгол Улсын хөрөнгө оруулалт, худалдааны орчны талаарх мэдээлэл, хөрөнгө оруулалт эрэлхийлж буй төслүүдийг гадаадын хөрөнгө оруулагч, | Хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан байна. | Х, Ш |

| | | | |
|---|---|---|---|
| | бизнес эрхлэгчдэд танилцуулж, сурталчлах зорилгоор бизнес/хөрөнгө оруулалтын форумыг санаачлан зохион байгуулах; | | |
| | 2.Олон улсын форум, уулзалт, үзэсгэлэн зэрэг арга хэмжээнд оролцох бэлтгэл ажлыг хангах; | Хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан байна. | Х, Ш |
| | 3.Хөрөнгө оруулалт эрэлхийлж буй, санхүүгийн эх үүсвэр нь шийдэгдээгүй төслүүдийг сонгон шалгаруулж, тэдгээрийг чадавхжуулах, төслийн мэдээллийн сан үүсгэх, бэлэн байдал хангагдсан төслүүдийг хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд танилцуулж, сурталчлах; | Хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан байна. | Х, Ш |
| | 4.Үндэсний брэндийг олон улсын тавцанд сурталчлан таниулах ажлыг шат дараатайгаар удирдан зохион байгуулах; | Хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан байна. | Х, Ш |
| | 5.Хөрөнгө оруулагч, бизнес эрхлэгчдэд зохиулсан гарын авлага, төслийн танилцуулга, хөтөч ном зэргийн эхийг бэлтгэж, хэвлүүлэх. | Төрийн үйлчилгээ сайжирсан байна. | Х, Ш |
| 6 дугаар зорилтын хүрээнд | 1.Монгол банк, санхүүгийн зохицуулах хороо, хөрөнгийн бирж, хөдөлмөр эрхлэлт, татвар, гааль, бүртгэл, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагуудтай хамтран хөрөнгө оруулалт, худалдааны нэгдсэн статистик мэдээллийг гаргах; | Мэдээллийн сан бий болж, төрийн үйлчилгээ шуурхай хүртээмжтэй, эргэн тайлагнасан байна. | Х, Ш |
| | 2.Холбогдох байгууллагаас авч нэгтгэсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, зохих арга хэмжээ авч | Хууль тогтоомжид нийцүүлэн арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. | Х, Ш |

| | | | |
|---|---|---|---|
| | хэрэгжүүлэх. | | |
| 7 дугаар зорилтын хүрээнд | 1.Удирдлагын шийдвэр, дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийх; | Хууль тогтоомжид нийцүүлэн эргэн тайлагнасан байна. | Х, Ш |
| | 2.Аппаратын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, шаардлагатай статистик тоон мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлэх; | Хууль тогтоомжид нийцүүлэн мэдээллийн сан бий болж, төрийн үйлчилгээ сайжирсан байна. | Х, Ш |
| | 3.Санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллах; | Хууль тогтоомжид нийцсэн байна. | Х, Ш |
| 8 дугаар зорилтын хүрээнд | 1.Газрын бүтцийн нэгж, албан тушаалтнуудад салбарын хууль тогтоомжийн талаар хууль зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж, эрх зүйн мэдээлэл, сурталчилгааны ажлыг зохион байгуулах; | Хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулсан байна. | Х, Ш |
| | 2.Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд газрыг хууль тогтоомжийн хүрээнд төлөөлж, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах; | Хууль тогтоомжид нийцүүлсэн байна. | Х, Ш |
| | 3.Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, албан хаагчдын ажиллах нөхцөл, эрүүл мэндийн үйлчилгээ, нийгмийн баталгааг хангах, сургалт, мэдээллийг хариуцах, газрын даргад бүх талын дэмжлэг үзүүлэх; | Хууль тогтоомжид нийцүүлсэн байна. | Х, Ш |
| | 4.Газрын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх; | Хууль тогтоомжид нийцүүлсэн байна. | Х, Ш |
| | 5.Газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийг хөтлөн явуулах, хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах ажлыг зохион байгуулах; | Хууль тогтоомжид нийцүүлсэн байна. | Х, Ш |

| | | | |
|---|---|---|---|
| | 6.Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах асуудлыг зохион байгуулах, зохицуулах; | Хууль тогтоомжид нийцүүлсэн байна. | Х, Ш |
| | 7.Газрын мэдээллийн технологи, мэдээллийн сүлжээ, санг хөгжүүлэх; | Хууль тогтоомжид нийцүүлсэн байна. | Х, Ш |
| | 8.Газрын үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, архив, албан хэрэг хөтлөлтийг тогтмол шуурхай эрхлэн явуулах. | Хууль тогтоомжид нийцүүлсэн байна. | Х, Ш |

| III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА | | |
|---|---|---|
| Боловсрол | Магистр ба түүнээс дээш боловсролын зэрэг хамгаалсан. | |
| Мэргэжил | - Эдийн засаг /0311/;<br>- Менежмент ба удирдахуй /0413/;<br>- Эрх зүй /0421/. | |
| Мэргэшил | Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх. | |
| Туршлага | Төрийн албанд 12-оос доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 6-аас доошгүй жил ажилласан байх, | |
| Ур чадвар | Удирдан зохион байгуулах | - хөгжлийн бодлого, төлөвлөлтийн дагуу тухайн салбарын бодлогыг төлөвлөх, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;<br>- байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлийг тодорхойлж хэрэгжүүлэх, хяналт тавих;<br>- төр, засгийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл, үр дүнг хариуцаж, үүрэг, хариуцлага хүлээх;<br>- газрын үйл ажиллагааг зохион байгуулж, гүйцэтгэлийг дүгнэх;<br>- санхүүгийн болон хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх;<br>- эрсдэлийг урьдчилан тооцоолох, гарах арга замыг тодорхойлох, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх. |
| | Дүн шинжилгээ хийх | - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж, дүгнэх;<br>- мэдээлэлд тулгуурлан бүтэц, чиг үүргийн шинжилгээ хийх, системийн шинжилгээ хийх, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх;<br>- бодлогын үндэслэлтэй зөвлөмж боловсруулах, зөвлөгөө өгөх;<br>- мэдээлэлд тулгуурлан салбарын асуудлаар дүн шинжилгээ, харьцуулсан судалгаа хийх; |

| | | |
|---|---|---|
| | | - бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах;<br>- хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, дүн шинжилгээ хийх;<br>- бусад. |
| | Асуудал шийдвэрлэх | - үндэсний язгуур эрх ашигт нийцүүлэн стратегийн түвшинд шийдвэр гаргах;<br>- хөрөнгө оруулалт, худалдааны бодлогын залгамж чанарыг хадгалах, хэрэгжүүлэх;<br>- аливаа асуудлыг албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;<br>- хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдвэрийг шуурхай гаргах;<br>- гаргасан шийдвэрийнхээ үр дагаврыг хариуцах;<br>- бусад. |
| | Манлайлах | - Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчлэх;<br>- хөрөнгө оруулалт, худалдааны үйл ажиллагааны шинэтгэлийн үзэл санааг тайлбарлан таниулах, хэрэгжүүлэх;<br>- ажил хэргийн хувьд зарчимч, бүтээлч, санаачилгатай ажиллах;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд үлгэр дуурайлал үзүүлэх;<br>- байгууллагын шинэчлэлт, өөрчлөлтийг удирдан манлайлах;<br>- ёс зүйн соёлыг төлөвшүүлэх, үлгэрлэн манлайлах; |
| | Бусад | - англи хэлний бичгийн болон ярианы чадвар дээд түвшинд байх (2 болон түүнээс дээш гадаад хэлтэй бол давуу тал болно);<br>- оролцогч талуудын олон талт байдлыг зохицуулах;<br>- мэдээллийн технологийн болон зайлшгүй шаардлагатай бусад ур чадвартай байх;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;<br>- мэдээллийг шуурхай хүргэх, мэдээлэл солилцох соёлыг төлөвшүүлэх;<br>- жендэрийн тэгш байдлыг хангах;<br>- кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх. |

## IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:
Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, дэд сайд

| Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: | Бусад харилцах субъект: |
|---|---|
| - нэгжийн удирдлагууд - 5<br>- ахлах мэргэжилтэн - 5<br>- мэргэжилтэн - 20<br>Нийт 30 | - Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;<br>- Яамд, агентлагууд;<br>- Төрийн албаны зөвлөл;<br>- Төрийн бусад байгууллагууд болон орон нутгийн байгууллагын холбогдох албан тушаалтан;<br>- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдийн ажилтан;<br>- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага, бусад хуулийн этгээд. |

## V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

| Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
|---|---|
| Албан тушаал:<br><br>Монгол Улсын Шадар сайд бөгөөд<br>Эдийн засаг, хөгжлийн сайд<br>....................... /Ч.Хүрэлбаатар/<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>20... оны ... дугаар сарын....-ны өдөр | Байгууллагын нэр:<br><br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: ...............................<br>Дугаар: ............ |

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр: Монгол Улсын Засгийн газар

Шийдвэрийн огноо: ...........................

Дугаар: .............

(тамга/тэмдэг)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД .................................. Л.ОЮУН-ЭРДЭНЭ

(Гарын үсэг) (Эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр)

20 .... оны .... дугаар сарын .... -ны өдөр